

II. Монголын дундат зууны түүхийн асуудал

МОНГОЛ УЛСЫН ТӨР: 800 ЖИЛ¹

Дэвид Снийт (David Sneath)

Кембрижийн Их Сургууль. Нийгмийн хүн судлалын тэнхим

Өгүүллийн товч утга: Монгол улсаас Их Британи, Умарт Ирландын нэгдсэн вант улсад суугаа Элчин сайдын яамнаас 2006 оны 4 дүгээр сард Их Монгол улс байгуулагдсны 800 жилийн ойд зориулан Английн монголч эрдэмтэд, түүх сонирхогч оюутан, магистрант, докторантууд оролцсон уулзалт ярилцлага зохион байгуулсан. Энэхүү өгүүлэл нь тэрхүү ярилцлагад тавьсан гол илтгэл болой. Эл өгүүлэлд Их Монгол улс байгуулагдсан түүхэн ач холбогдол, төр ёсны уламжлал, язгууртны гарал угсаа, Чингисийн алтан ургийн тухай өгүүлжээ.

Түлхүүр үг: Их Монгол улс, төр ёсны уламжлал, Чингис хаан, алтан ураг, трайбализм.

1206 оны бар жилд Тэмүжинг дэмжигч ноёд язгууртнууд түүнд Чингис цол олгож, Их Монгол улсын хаан суудалд өргөмжлөн Монгол Улсын төрийг албан ёсоор тунхагласан бөгөөд энэ нь он цагийн хувьдаа өрнө дахинд байгуулсан олон төрөөс харьцангуй эрт үед юм.

Түүнээс хойш XX зуунд Монгол Улс тусгаар тогтнолоо олох хүртэл Монгол Боржигиний удам судар буюу Чингисийн алтан ургийн хэлхээ алдраагүй үргэлжилсэн билээ. Боржигидийн уламжлал буюу Монголын ноёрхол олон зууны дайсангал заналхийллийг тухайлбал магадгүй хамгийн ноцтой нэг нь болох XV зууны Ойрадын бослого зэргийг туулан үргэлжлэн тогтножээ.

Мандухай сэцэн хатан болон Даян хааны хичээл зүтгэлийн үрээр шийдвэрлэсэн гэр доторх асуудал Чингисийн алтан ургийн хэлхээг аварсны ачаар бид өнөөдөр Ойрадын биш, харин Монгол Улсын элчин сайдын яаманд байгаадаа талархах ёстой. Монголчуудын туулсан он жилүүд тэднийг түүхэн дэх хамгийн нөлөө бүхий үндэстнүүдийн нэгэн болгосон юм. Дундад зуунд Чингисийн алтан ургийнхны байгуулсан аугаа их хаант улсыг дурдах нь илүүц зүйл болох бизээ.

Бидний нэрлэж заншсан түүхэн дэх хуучин ертөнцөд Монголын эзэнт улс хамгийн анхны дэлхийн гүрэн байсан. Европ болон Ази хоёр тивийг хамгийн анх удаа

¹ Энэхүү өгүүлэл нь Дэвид Снийтийн хэвлэлд бэлэн болгоод байгаа Монголын төрийн тухай номны удиртгалын товчлол болно.

шууд холбож, Евроази тивд Монголын ноёрхол дор нэгэн үеийн энх тайвныг тогтоосон юм. Шашин шүтлэг, соёл, нийгмийн хэв заншлын хувьдаа олонлог болсон, нээлттэй хүлээн зөвшөөрөгдсөн улс байсан тухай олонтаа дурддаг. Энэхүү нээлттэй хүлээн зөвшөөрөх бодлогыг бид эртний бүдүүлэг энгийн төр гэсэн нэрээр үл ойшоож байсныг эргэцүүлэн энэ бол удирдагчдийн уран чадвар, боловсронгуй нарийн арга ухаантай төрийн шинж гэж залруулах шаардлага тулгарч байна.

Бидний энэ улс болон бөмбөрцөгийн ихэнх хэсэг нь монгол гэдэг бол дэлхийн түүхэнд хосгүй ул мөртэй гэхээс өөр мэдлэггүй, эндүү ядуухан ташаа ойлголтуудаар дүүрэн байдаг. Нэгэн жишээ дурдвал, монгол гэдэг бол цаг хугацаагүй зэлүүд зэрлэг, хамгийн энгийн овгийн байгуулал ураг удмын бүтцээс арай илүүхэн зохион байгуулалттай бүдүүлэг овог аймгууд нутагладаг газар орон хэмээх төсөөлөл юм. Энэ төсөөлөл дотор Чингис хаан гэдэг хэн нэгэн гайхамшигтай бодгал гарамгай итгэл үнэмшил төрүүлэгч удирдагч болон зэрлэг бүдүүлэг гэр ордныхныг шүүрэн аваад хаяа нийлэн сууж байсан соёл иргэншлүүд рүү тараан цацсан мэт зураглал бий болгодог. Энэхүү нүүдэлчдийг нийгэм-соёлын бус харин байгалийн хүчтэй ойр хэмээх үзэл сэтгэлгээг өөрчлөхөд төвөгтэй гэдэг нь нотлогдсон хэрэг билээ.

Монгол төрийн тухай өрнө дахины ихэнх онол нүүдэлчдийн нийгмийг байгаль газар зүйн (экологийн) онцлогийн үүднээс харан тодорхойлж байсан. Ийм үзэл Дилеэз (Deleuze), Гуйттари (Guattari) (1986:73) нарын "нүүдэлчдэд түүх үгүй, харин газар зүй л бий"¹ гэх мэтийн дүгнэлтүүдэд нийтлэг харагддаг. Үнэндээ монголын төрт ёсны урт удаан түүх тэднийг нарийн нягт, өндөр зэрэгт боловсорсон, нөлөөлөх хүч бүхий шинэлэг, цогц зүйл болохыг нь илтгэн үзүүлдэг.

800 жилийн уламжлал гэдэг бол ямар ч үндэстэнд хангалттай эрхэм хүндтэй өв юм (энэ нь Европын олонх улсуудаас илүү байх жишээтэй). Цаашилбал, Монгол төрт ёс түүнээс ч өмнөх үеийн төрт ёсны уламжлалаас улбаатай билээ. Тиймээс Чингис хаан болон Боржигин удмынхны Монгол төр өнө удаан жилийн настай, нарийн боловсронгуй улс төрийн хөгжлийн баялаг түүхийн нэгэн хэсэг гэж хэлэх нь миний бодлоор мэдээлэл ихтэй дүгнэлт гэсэн үг болно.

Гол гол улс төрийн байгууламжууд Түрэгийн хаант засгийн уламжлалын хөгжил байсан бөгөөд харин тэр нь Загалмайтны тооллын өмнөх III зууны Хүннү нарын улс

¹ Deleuze, G., and Guattari, F., 1986, *Nomadology: The War Machine* (Номадологи: Дайны Машиин), Semiotext(e), Colombia University, New York, Minneapolis: University of Minnesota Press

төрийн хэлбэр дээр үндэслэн бий болсон юм. Энэ бол Каролинган (Carolingian) юм уу, эсвэл Оттониан (Ottonian) Европ дахь Ромын захиргааны уламжлал шиг нэг бол өнгөрсөн “харанхуй үеийн” шалтгаанаар балран мартагдсан зүйл, эсвэл засгийн газрын албан бичиг, хэвлэлийн аль аль нь биш юм. Харин ч энэ засаглал нь хожмын шинэ хаант төрийн уламжлал, үйл хэрэгт зохих хэмжээний ул суурь болж өгчээ. Тэдний засах удирдах тогтолцоо нь эргэн тойрон дах “илүү нарийн” гэгдэх хөршүүдээс зээлдэн хуулбарласан зүйл бус, харин Монгол улсыг бий болгон, хээр талд үүсэн бий болж, нарийсан хөгжиж, зохицон нийцсэн хээрийнхний уламжлал юм.

Энэ баялаг төрийн өв уламжлалд олон онцлог байдгийг би цөөхөн хэдийг нь дурдъя.

Дээд язгууртны гарал: Нэн тэргүүнээ миний бодолд өндөр дээд язгууртны гарлын тухай асуудал бууж байна. Монгол бол зэрлэг бүдүүлэг овог аймгуудын нутаг гэхээсээ илүү язгууртнууд, тэднийг хүрээлэн дагагсад, дэмжигчдийн нутаг мэт санагдаж байна. Тал дахь ихэс дээд язгууртнуудын гэр отгийнхон нэгэнтээ шашин, урлагийн тэргүүлэгчид, нарийн боловсорсон улс төрийн зүтгэлтүүд, цэргийн гарамгай удирдагчид байсан бүлгээ.

Загалмайтны тооллын өмнөх III зууны Хүннү гүрний үеэс аваад хорьдугаар зуун хүртэлх бидний мэдэх түүхийн баримтаас үзвэл ийм язгууртнууд Өвөр Азийн анхны улс төрийн гол онцлог нь болж байжээ. Эртний хятадын түүхч Сима Чианы (Sima Qian) дүрсэлснээр бол Хүннү гүрний язгууртнууд гурван гэр бүлээс бүрдэх ба хаан залгамжилсан эрх бүхий хэдэн өндөр тушаалын ноёдоор дамжуулан захиргаагаа тогтоож байжээ. Язгууртнуудын албат иргэдийг нэрлэж байсан нэр томъёоноос энэ тухай үргэлжлүүлэн сонирхмоор мэдээлэл гарч байна. Албат иргэдийг Түрэгийн ноёрхолын үед *qara* буюу “хар” гэдэг байжээ¹. Эндээс гаралтай *qarachu* (харц) хэмээх мөн л албат иргэн гэсэн утгатай үг монгол хэлэнд наад зах нь XIII зуунд байсан нь тодорхой байдаг. Энэ нь орчин цагийн монгол хэлний “харц” буюу “энгийн хүн” гэсэн үгний язгуур болж таарч байна. Гэхдээ *qarachu* хэмээх үгийн ардах улс төрийн агуулга нь илүү төвөгтэй бөгөөд “хамжлага, зарц” гэсэн утгад илүү нийцнэ.

¹ Энэ үгийн тухай Синор (Sinor) бас бичсэн байна (1990: 310). Sinor, D. 1990, The Establishment and Dissolution of the Türk Empire (Түрэгийн Хаант Улсын тогнол болон мухардал), in *Cambridge History of Early Inner Asia* (Кембрижийн эрт үеийн өвөр азийн түүх), ed. Senior, Cambridge: Cambridge University Press.

Монголын анхны төрийн түүхийн нарийвчилсан судалгаанаас үзвэл Чингис хаан болоод түүнийг дэмжигсэд хээр талынхны хүч, боловсронгуй ухааныг нэгтгэн зангидаж, түүнийг илрүүлэн биежүүлж гаргаж ирсэн байна. Энэ агуулга нь тэднийг олон жил хүчтэй үргэлжилсэн бүдүүлэг овгийнхон төдийхнөөр төсөөлж байсан явдал, XIX зууны “хөгжил хувьслын” (evolutionist) онолчдын нүүдэлчин нийгэм гэдэг нийгмийн хөгжлийн шатны хувьдаа дээхэн үед хамаарах газар тариалан, хотжилтоос түрүү үеийн балар бурангуй амьдралын хэлбэр гэх тодорхойлолтод дарагдан бүрхэгдэн үлдсэн юм. Хэдийгээр энэ буруу ойлголт олон том эрдэмтдийн эсэргүүцэлтэй тулгарч байсан ч бидний [өрнө дахин] түүхэнд, ялануяа Европын колончлолын үеэд, монголыг төлөөлөн үлдсэн баримт сэлтэд ул мөрөө гүн үлдээсэн байна. Нуттай жишээ болгон ташаа орчуулгуудыг дурдаж болно. Европт дахь монгол төрийн тухай анхны мэдээ сурвалжууд гэвэл Жон ди Плано Карпини (John di Plano Carpini), Рубруккийн Виллиам (William of Rubruk) зэрэг загалмайтны лам нарын тэмдэглэл юм.

Тэд анх монголын язгууртнуудтай уулзахдаа тэднийг “Dux” мэтээр адилтган дүрсэлсэн. Хаклуэт (Hakluyt) мэтийн дээхэн үеийн орчуулагчид мөн л “Duke” хэмээн орчуулсан бөгөөд эртний англи сурвалжид католикийн гэлэн лам нар Монгол Duke нартай уулзсан байдлаар дүрсэлдэг. Харин Европын колончлолын үед энэ орчуулга өөрчлөгджээ. XIX, XX зууны орчуулагчид монголыг нүүдэлчин гэж үзэн түүнээсээ улбаалуулан тийм бол овог аймгийн зохион байгуулалттай (tribal) гэхчилэн ялган гадуурхах хандлагыг бий болгосон байна. Ингээд европыхныг нэрийдсэн “Dux” гэдэг үгийг “Duke” хэмээн орчуулаад монголчуудыг нэрийдсэн “Dux” гэдгийг “chief” буюу “удирдагч, тэргүүлэгч” гэсэн үгээр орчуулах болжээ.

Өөр нэгэн жишээ бол “horde” хэмээх үгийн гарал юм. Энэ үг хүй нэгдлийн үеийн бүдүүлэг зэрлэг, хөл толгойгүй замбараагүй бүлэг хүмүүс гэсэн утгатай монгол хэлнээс зээлдэн авсан үг байлаа. Энэ нь дээхэн үеийн хүн судлаачдын хүний нийгмийн хөгжлийн шатыг хиймлээр тогтоох гэсэн оролдлоготой холбоотой. Энэ утгаараа дээрх үг хамгийн энгийн нийгмийн хэлбэр болох “анчин, жимсчин” (hunter gatherer) амьдралыг илэрхийлж байдаг. Үнэндээ *horde* хэмээх үгийн язгуур утга буюу монгол хэлэн дэх *ordu* гэдэг нь хааны орд гэсэн утгатай. Тухайлбал Оросыг захирч байсан *Golden Horde* буюу “Алтан Орд” бол хүй нэгдлийн зэрлэгүүд биш, харин Бат хаан болоод түүний залгамжлагч нарын төрийн танхим орд харш юм.

Ordu гэдэг үгийн англи хэлэн дэх хувилбар нь Европынхны өөрсдийнх нь төрөөс яльгүй ондоо боловч, харийн гүрний учир битүүлэг төрийн тухай ядуухан ойлголтын хар гайгаар бий болсон өрөөсгөл ухамсарын нэгэн жишээ гэлтэй. Европынхонд магадгүй нэг л их эмх журамгүй хүн, мал, гэр отог үзэгдсэн байлтай. Гэтэл үнэндээ жинхэнэ хөл толгойтой, нарийн учиг учиртай, боловсронгуй зохион байгуулалттай улс төрийн байгуулал нь тэрхүү *Ordu* дотор байсан билээ. Энэ мэтийн өрөөсгөл ойлголт бидний мэдэх монголын түүх, бидэнд нэн тэргүүнээ дүрслэгддэг овог аймаг, зэрлэг бүдүүлэг дүр зургийг бий болгох үндэслэл нь болж, тэдний хүчирхэг сүр жавхлангийнх нь өнгө будаг нь болсон байна. Үүнээс гадна элбэг тохиолдох бас нэгэн өрөөсгөл ойлголтын учиг нь Монголын төрийг зэрлэг бүдүүлэг дайчин баатруудын харгислалаас үүдсэн айдас ноёлсон дорно дахин дахь эзэрхэг түрэмгийлэл гэсэн үзэл юм. Харин үнэндээ бид хүлээцтэйгээр түүхийг сонсвол (хэрвээ хүвэл) бодит байдал үүнээс яг эсрэг байсан нь илэрхий байдаг.

Талын язгууртнуудын хүч харин ч захирагч хаанаасаа харьцангуй тусгаар бие даасан шинжтэй байсан бололтой. Тухайлбал, XVII зууны эхэн гэхэд Лигдэн Хааны захиргаанд байсан олонх алтан ургийн ноёд өөртөө засах эрх мэдэл бүхий байжээ. Үүнийг гэрчлэх нэгэн баримт бол өмнөд болон зүүн монголын хэсэг ноёд өөрсдийн захирагч ноёнд өгсөн андгайгаа цуцалж хожмын Манж Чин улсын өвөг болох Жингийн Нурхачи ноёд зүтгэхээр андгай тавьсан явдал юм. Энэ явдал Лигдэн хаан болоод бусад алтан ургийн ноёдын алтан ураг хэлхээ нь улс төрийн ашигтай тэмцлээс илүү чухал биш гэдгийг харуулж байна. Ингэж үзвэл тэдний улс төрийн зохион байгуулалт ураг төрлийн холбоон дээр суурилсан гэр зуурын хүрээ хэмжээний энгийн хэлбэр байгаагүй, харин ч нарийн хөгжин боловсорсон улс төрийн соёл байжээ. Хаант засаглал нь шашин шүтлэгийн болон санаалаг хийсвэр ухамсар дээр тулгуурласан байсан бололтой.

Тэнгэрээс заяат эрх: Үүний жишээ нь тэнгэрээс заяат эрхийн тухай маргаантай асуудал бөгөөд энэ утгаараа төрийн тухай хийсвэр сэтгэлгээ нэн эрт үед хамаарна. Хүннүгийн эзэн “хаан тэнгэр газраас заят төрсөн наран саранд ивээгдсэн” гэж гардаг нь Түрэгийн хаадын (Qaghan) “тэнгэрээс төрсөн” болон Чингис хаан, түүний өвөг дээдсийг “тэнгэрийн хүү” гэхчилэн цоллодог байсантай адил юм¹.

¹ Буха Хатаги, Бухату Салжи, Бодончар Мунхаг гуравт эх нь “та нар бол тэнгэрийн хөвгүүд, бүхний хаад удирдагчид болох заяатай” гэхчилэн сургасан тухай Монголын Нууц Товчооны 21-р зүйлд дурдсан байдаг.

XVII зуунд Манжийн эзэн хаан Нурхачи Чингисийн алтан ургийнхныг дарахын тулд улс төрийн үйл хэрэгтээ өөрийгөө тэнгэрийн хүү хэмээн тунхаглаж байсан бөгөөд түүний амжилт нь ч түүний тунхаглалыг нотолсон мэт зүйл болсон билээ. Тэнгэрээс заяасан эрх хэмээх сэтгэлгээ нь өмнөх үеийн Өвөр Азийн олон удирдагчдын улс төрийн нэр хүндийг бүрдүүлэгч хэсэг нь болж байсан бөгөөд энэхүү уламжлалт сэтгэлгээ боломж таарсан үед язгууртнуудын гэр отгийг эзэнт гүрний хааны язгуурын хэмжээнд аваачихад тус болж байжээ. Монгол-Түрэг угсаатны уламжлал дахь тэнгэрээс заяат эрхийн тухай ойлголт нь хөрш хятад үндэстний тэнгэр шүтэх үзэлтэй адилгүй боловч тэнгэрээс заяат, “тэнгэрийн хүү” гэх ойлголт олон мянган жилийн түүхтэй хятадын хаадаа “тэнгэрийн хүү” гэж өргөмжилдөг уламжлалтай адил төстэй болох нь тодорхой юм. Ялангуяа энэ ойлголт Юань гүрний үед монголчууд хятадыг эзэлж байсан хэрэг явдалд чухал ач холбогдолтой бүлгээ.

Нийтийн¹ дархан эрх: Монголын улс төрийн бас нэгэн онцлог нь өмнөх үеийн Түрэгийн улс төрийн бодлогын үеэс угшилтай олны эрх юм. Улс төрийн хүч түрэмгийлийн аргаар нэгэн дээвэр дор нэгтгэгдэн дорнын дарангуйлагчийн гарт зангидагдаж байдагтай адилгүйгээр, удирдахуй ухааны арга нь олон талаараа захирч буй гэр удмынхны нийтийн хэрэг бөгөөд энэхүү дархан эрх гэдэг бол толгой тэргүүн нь адил үүрэг гүйцэтгэж байдагт оршино. Энэ нь цаашдаа удирдаж буй нэгэн гэр удмын хэд хэдэн залгамжлагчдын хаан ширээний төлөөх нэлээд төвөгтэй өрсөлдөөн болон өрнөх магадлал бүхий байдаг. Түүнчлэн Монголын эзэнт гүрэнд байсан шиг тэргүүлэн захирах нэгэн гэр удмынхны ахмад гишүүд болон тэднийг залгамжлагчид ялгаагүй бүгд тодорхой хэмжээний хувь хүртэж байдаг.

Хаант төрийг засах өөр нэгэн түгээмэл арга нь орон нутгийн захирагч нарыг хаанд үнэнч болох эсэхийг нь нотлон баталдаг байсан явдал юм. Чингисийнхний ноёрхлын үед хээр талын “хуучин нүүдэлчин” язгууртнууд болох Киданчууд болон Хутлуг Хаад (Qutlugh Khanids) сайн байршуулсан байсан. Бүхий л тохиолдолд тухайлбал Чингисийн алтан ургийн, Ойрадын эсвэл Манжийн ч юм уу ноёрхолын үед газар нутаг болон хамжлагуудаа хамгийн ойр нутаглах язгууртны гэр отгийн мэдэлд байлгах бөгөөд цаашлаад тэдгээр нь бүх л улсын хэмжээний янз бүрийн томоохон бодлогын нэгэн бүрэлдэхүүн хэсэг болдог байв. Ийм удирдлагын хэлбэр хаант

¹ [Энд нийтийн гэдэг үг бүхэл олон нийт ард түмэн гэсэн утгаар биш харин алтан ургийн ч юм уу эсвэл улс орныг захирч байгаа нэгэн гэр удмынханы хүрэн дэх бүх нийтийг хэлж байгаа].

засгийн хүчний төвлөрлийг сарниулж сулруулах талтай нь илэрхий хэдий ч бас жолоодогч гэр удмынхны нийтийн дархан эрхийг бататгаж, язгууртнуудын тэгш эрх ганц хүний ноёрхолыг хязгаарлаж байдаг.

Трайбализм (tribalism) [овгийн байгууламж] төр (the state) хоёрын хоорондох зөрчилдөөн гэгдэн хаягдан үлдэж байгаа нийтлэг зүйлийг миний бодлоор их бага ямар боловч төвлөрлийг бий болгосон үйл явц болон тогтсон язгууртны дэг жаягийн хаант засгийн хувилбар гэж үзэх хэрэгтэй. Чингисийнхний энэхүү нийтийн дархан эрх хэмээх ойлголт Чин улсын үед хүртэл чухалчлагдан уламжлан ирсэн байна. Улс байгуулагдсан эхэн үедээ Чин улс монголыг захирахдаа алтан ургийн язгууртнуудыг орон нутгийн засаг захиргааны ноёд хэвээр үлдээгээд дээр нь нэмж Чингийн цол хэргэм, захирах эрх олгож байсан билээ. Зарим чухал тал дээр, алтан ургийнхан улс төрийн удирлан жолоодох үйл хэрэгт бүгд бүх нийтээр оролцож байсан. Тэр ч бүү хэл Чин улсын албан тушаалгүй ч байсан алтан ургийн хүн л бол оролцож байсан байдаг.

Тэд татвар болон энгийн ардуудын ноёд гүйцэтгэх ёстой хөдөлмөрийн болоод бусад үүргүүдээс чөлөөлөгдсөн бас өөрсдийн хувийн бараа бологч зарцтай байх эрхтэй байжээ. Дээд язгууртнуудыг шийтгэх хэлбэр жирийн ардуудынхаас бас ондоо, ихэвчлэн малын тоо хэмжээгээр торгох шийтгэл хүлээдэг байсан байна. Гэтэл ардуудыг хууль зөрчсөн бол ташуурдах, боолчлох, алах ял оноодог байжээ. Нийтийн дархан эрхийн сүлд сүнс нь язгууртнуудын чуулган байв. Түүний хуралдаанаар алтан ургийн хаадуудыг сонгон өргөмжилдөг байсан нь Манжийн засаглалаас түрүү үеийнх боловч Халх Монголын аймгуудыг мөн ийм л зарчмаар захирч байсан байна.

Цэргийн бүхэллэг тоот тогтолцоо болон иргэний захиргаа: Алтан ургийнхны төрийн өөр нэгэн цохон тэмдэглүүштэй онцлог гэвэл цэрэг болон иргэний бүхэллэг тоот тогтолцоо юм.

Мянган морьтон цэрэг нэгэн нэгж болох бөгөөд түүний хүчийг захирагчийг мянгатын ноён гэдэг. Мянгат доторх нэгж нь арван зуутын нэгжээс бүрдэх ба зуутын нэг нэгж арван аравтын нэгжээс (эхэндээ арван гэдэг байгаад аажимдаа аравт гэх болсон) бүрдсэн тогтолцоотой байжээ. Энэ тогтолцоог ямагт Чингис хаан үүсгэсэн гэх ба энэ мэтчилэн нөгөө бүдүүлэг, авъяслаг удирдагч маань овгийн байгуулал бүхүй нийгмийн хэлбэрийг “дайны машин” болгон хувиргасан нь энэ. Овгийн зохион байгуулалттай нүүдэлчин нийгмийг ийнхүү боловсронгуй тоон хэлбэртэй удирдлагаар сольсон нь судлаач тайлбарлагч олны гайхшралыг төрүүлсэн нь элбэг билээ.

Үнэндээ байдал үүнээс яг эсрэгээрээ байсан юм. Энэ засах жолоодох арга ухаан аль эрт загалмайтны тооллын өмнөх III зууны Хүннү нарын үеэс хөгжин боловсорсон байна. Хүннү гүрэн зүүн гал буюу дорнод хэсэг баруун жигүүр буюу өрнөд хэсэг гэсэн хоёр том жигүүрт хуваагдсан зохион байгуулалттай, тэдний бодлого нь цэргийн асар их хүч өмнө зүгт чиглэн байрласан байдалтай байжээ. Эзэн хааны (шаньюй) дор “бага хаад” болон баруун зүүн жигүүрийн тэргүүлэх ноёд байдаг. Тэдний дор “түмэн морьтон цэрэг” гэсэн цолтой хорин дөрвөн их ноёд байсан тухай Сима Чиан дүрсэлсэн байдаг. Тэд мянгаар багцалсан нэгжүүдийг захирах бөгөөд тэдгээр нь цаашаа зуут, аравт болон задардаг гэжээ. Энэ бол эртний улс төрийн соёл иргэншил бөгөөд язгууртнууд үүнийг тоолж, залж, захирч байсан байсан. Захиргааны эл зохион байгуулалт нь Түрэг болон Төвдийн хаант улсуудад жишиг болон уламжилсан бөгөөд түүнээс Чингис хааны Монгол Улс угшилтай юм.

Дараа дараах үед энэ захиргааны уламжлал өөрчлөгдөн шинэчлэгдсэн нь илэрхий байдаг. Тухайлбал XV зууны үед Чингисийн мянгатын тогтолцоо нь [эхлээд отог дараа] хошууны тогтолцоогоор солигдсон бөгөөд хошуу гэдэг нь угтаа түмэн морьт цэргээс бүрдэх нэгжийг заан нэрлэсэн утгатай байсан бололтой.

Чингисийн алтан ургийнхны үед зуутын (*ja'un*) нэгж хэрэглэгдэж байгаад үгүй болсон бөгөөд Чингийн үед харин “сум” гэсэн засаг захиргааны нэгж бий болсон нь тавиас зуун [150] цэргээс бүрдэж байжээ. Харин эгэл дорд аравтын нэгж (анхандаа *harban* гэдэг байгаад хувирч *aravt* болсон) XX зуунд Богд Хаант улсын үе хүртэл үргэлжилсэн байна.

Энэхүү боловсронгуй улс төрийн уламжлал 800 жил төдийхөнд үүсэн хөгжсөн биш, харин ч хоёр мянга гаруй жил болж, эртний төрийн ухаан хөдөлгөх хүч нь болж түүхийн явцад шинэчлэгдэн хөгжсөн, баялаг бүрэлдэхүүн тогтоцтой бөгөөд бидний мэдэх олон алдартай төрийн тогтолцоонуудтай эн зэрэгцэж байна. Өнөөгийн бидний мэдэх Чингис хааны болон түүний удмынхны биежүүлэн хэлбэржүүлсэн эртний удамт олноо алдаршсан Монгол төрийн 800 жилийн ойг тэмдэглэж байгаад хүндэтгэлээ илэрхийлж байна. Манж Чингийн ноёрхлолд байсан улсуудаас онцгойрон XX зууны эхэнд өөрийн тусгаар тогтнолыг тунхаглан үндэсний төр улсаа байгуулж, эдүгээ оршин байгаад Боржигиний язгууртнууд болон Боржигин бус энгийн ард иргэдийн гавъяаны үр шим юм.

XX зууны эхэн үед тулгарсан жанжин Сү [Сүшүжан] болон Барон Унгерний халдлага, тонуул зэрэг олон түүхэн явдлыг тоочвол энэ бол багахан амжилт биш юм.

Бид энэхүү өнө эртний түүхийг тэмдэглэнгээ ирээдүйн 800 жилийг “Монгол Улс Мандтугай!” хэмээх уриатайгаар угтан бэлгэшээх ёстой.

Abstract: The article covers a range of issues from historical significance of the foundation of the Great Mongolian State and its statehood traditions to the genealogy of Mongolian nobility and the Golden Lineage of Chinggis Khaan.